МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Түүх, угсаатны зүйн
хүрээлэн

МОНГОЛ УЛСЫН
“ЧИНГИС ХААН”
ҮНДЭСНИЙ МУЗЕЙ

ОХУ-ЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Дорно дахины гар
бичмэлийн хүрээлэн

МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ:
ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА

VI

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан

Олон улсын эрдэм шинжилгээний хурал

2023 оны 4 сарын 19-21
Монгол Улс, Улаанбаатар хот

Илтгэлүүдийн эмхэтгэл

Улаанбаатар – Санкт-Петербург
2025

ННА 63
ДАА 900
М-694

Хариуцлагатай редактор: Академич С. Чулуун
Эмхтгэгч-редакторууд: Хэл бичгийн шинжлэх ухааны доктор И. В. Кульганек
Түүхийн ухааны доктор (Ph.D), проф Н. Хишигт
Хэл шинжлэлийн дэд эрдэмтэн Д. А. Носов

Монголчуудын соёлын өв: Гар бичмэл ба архивын баримтын цуглуулга-VI. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. 2023 оны 4 сарын 19-21. Монгол Улс, Улаанбаатар хот. Улаанбаатар – Санкт - Петербург, 2025. – 320 тал.

Тус эмхэтгэлийг Монгол Улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, “Чингис хаан” Үндэсний музей, ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн хамтран 2023 оны 4 дүгээр сарын 19-21-нд Монгол Улсын Улаанбаатар хотноо зохион байгуулсан “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 6 дахь удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдээр бүрдүүлэв.

Энэхүү хурлыг зохион байгуулах эх суурь нь архив, гар бичмэлийн сан хөмрөгт хадгалагдаж буй монгол угсаатан ард түмнүүдийн хэл, түүх, улс төр, хэл, утга зохиол, шашин соёл, угсаатны зүйд холбогдох баримт материал болно.

Эмхэтгэлд монгол судлалын түүх, монголчуудын эдийн соёл, бичгийн өв, уран сайхны бүтээл туурвил, хээрийн шинжилгээний ангиудын тухай болон Монголын уламжлалт нийгэм, орчин үеийн амьдралын олон талт асуудлыг тусгасан гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүнийг судлан шинжилсэн илтгэлүүдийг багтаав.

ISBN 978-9919-533-04-5
DOI 10.48612/IVRRAN/1u5a-r7u3-48rg

© Монгол Улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, 2025
© Монгол Улсын “Чингис хаан” Үндэсний музей, 2025
© Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, 2025

МОНГОЛЬСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт истории и
этнологии

“ЧИНГИС ХАН”
Национальный музей
Монголии

РОССИЙСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт восточных
рукописей

КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: РУКОПИСНЫЕ И АРХИВНЫЕ СОБРАНИЯ

VI

Международная конференция
при поддержке Президента Монголии

19-21 апреля 2023 г.
Монголия. Улан-Батор

Сборник докладов

Улан-Батор — Санкт-Петербург
2025

ННА 63
ДАА 900
М-694

Ответственный редактор: Академик С. Чулуун
Редакторы-составители: доктор филол. наук И. В. Кульганек
доктор (Ph.D), проф. Н. Хишигт
кандидат филол. наук Д. А. Носов

Культурное наследие монголов: Рукописные и архивные собрания. Сборник докладов VI Международной научной конференции. 19-21 апреля 2023. Улан-Батор, Монголия. УБ. — СПб., 2025. — 320 с.

Сборник представляет собой собрание докладов VI Международной научной конференции “Культурное наследие монголов: рукописные и архивные собрания», организованной Институтом истории и этнологии МАН, Национальным музеем Монголии Чингис-хан и Институтом восточных рукописей РАН в Улан-Баторе 19-21 апреля 2023 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, политике, языку, литературе, культуре, религии и этнографии монгольских народов.

В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN 978-9919-533-04-5
DOI 10.48612/IVRRAN/1u5a-r7u3-48rg

© Институт истории и этнологии МАН, 2025
© "Чингис-хан" Национальный музей Монголии, 2025
© Институт восточных рукописей РАН, 2025

MONGOLIAN ACADEMY
OF SCIENCES
Institute of History and
Ethnology

CHINGGIS KHAAN
NATIONAL MUSEUM
OF MONGOLIA

RUSSIAN ACADEMY
OF SCIENCES
Institute of Oriental
Manuscripts

CULTURAL HERITAGE OF THE MONGOLS: MANUSCRIPT AND ARCHIVAL COLLECTIONS

VI

International Conference
Under the Patronage of the President of Mongolia

April 19-21, 2023.
Mongolia, Ulaanbaatar

Proceedings

Ulaanbaatar – St. Petersburg
2025

ННА 63
ДАА 900
М-694

Edited and compiled by Academician S. Chuluun
D.Sc.(Philology) I. V. Kulganek
Ph.D (History), prof N. Khishigt
Cand. Sc. (Philology) D.A. Nosov

Cultural heritage of the Mongolis: Manuscripts and archival collections-VI. Papers of the VI International Conference, April 19-21, 2023. Ulaanbaatar. Ulaanbaatar-St.Petersburg 2025, 320 pages.

This is a collection of papers, presented at the Sixth International Conference organized by the Institute of History and Ethnology of the Mongolian Academy of Sciences, National Museum of Mongolia "Chinggis Khaan" and the Institute of Oriental Manuscripts of the Russian Academy of Sciences, which was held in Ulaanbaatar in April 19-21, 2023.

The basis for the conference was hand-written funds and archives, storing documents and materials on history, culture, ethnography, politics and language of the Mongolian peoples.

The collection publishes reports on the history of Mongolian studies, as well as reports on handwritten material on the Mongolian culture, their written heritage, artistic creativity, expeditions and the problems of traditional and Modern Mongolian society.

ISBN 978-9919-533-04-5
10.48612/IVRRAN/1u5a-r7u3-48rg

© Institute of History and Ethnology MAS, 2025
© National Museum of Mongolia "Ghinggis Khaan", 2025
© Institute of Oriental Manuscripts RAS, 2025

ГАРЧИГ / СОДЕРЖАНИЕ

ӨМНӨХ ҮГ 10

МЭНДЧИЛГЭЭ /ПРИВЕТСТВИЯ..... 11

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 6 дугаар удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцогсдод ирүүлсэн илгээлт..... 12

Приветственная речь Генерального секретаря Международной ассоциации монголоведения, директора Национального музея Монголии Чингис-хан, академика С. Чулууна 14

Приветствие директора Института восточных рукописей РАН, член-корреспондента РАН И. Ф. Поповой 16

Монгол Улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал, (Sc.D) Ц. Цэрэндоржийн мэндчилгээ..... 18

ИЛТГЭЛҮҮД / ДОКЛАДЫ

Г. Алтансүх
Нур ад-Дины гар бичмэл дундад зууны монгол хүний нэрийн сурвалж болох нь 22

Г. Баярмаа
Берлиний Улсын номын санд хадгалагдах Монголын бурханы шашинд холбогдох баримтын тухай..... 28

Т. Баясгалан
Арташид хан хөвгүүний туужаас сэдэвлэсэн монгол тууль 43

Л. Ганбат
“Zafarnama” Монголын түүхэнд холбогдох сурвалж болох нь..... 52

Д. Дашдулам
1932 оны зэвсэгт бослогын нэгэн удирдагч Самбуу дүвчингийн тугийн талаар нэхэн үзэх нь 58

Ц. Дэлгэрсайхан
Монгол Улсын боловсролд Оросын сургагч багш, мэргэжилтнүүдийн оруулсан хувь нэмрийг архивын баримтаар тодотгох нь (1912-1942 он)..... 76

Zsolt Szilágyi
The Hungarian press perceptions of Mongolia at the beginning of the 20th century..... 89

И. М. Захарова
Караван купца Ивана Саватеева в Китай в 1702-1704 гг.
(По материалам Государственного Эрмитажа)..... 99

И. В. Кульганек
«Речь о состоянии монгольской словесности» из собрания
Института восточных рукописей РАН 108

Лицю Лю, Р. М. Валеев, Р. З. Валеева, Ю. И. Елихина, Д. Е. Мартынов
Формирование монголоведения, буддологии и тибетологии
в Казани в XIX в.: архивные фонды и материалы государственного
архива Республики Татарстан и музеев Казани 120

М. В. Мандрик
Коллекция документов по истории Русской духовной миссии
в Пекине и Монголии в собрании Научного архива ИИМК РАН 140

Д. Наранцэцэг
Хорчинба Ишжамцын намтар “Сүсэг төгөлдөр нугуудын зүрхний
энэлгийг арилгагч” хэмээх зохиолын шинжлэл 149

Б. Нацагдорж
Монгол Гэсэрийн туужийн үйсэн дээр бичсэн нэгэн эхийн тухай 162

Д. А. Носов
Загадка тетрадей Лисовского: о составе единицы хранения
« В.И. Лисовскийн тэмдэглэлийн дэвтэрүүд» из Центрального
Национального Архива Монголии 178

G.Odbayar
A Contribution to the study of Mongol bannermen: The founding policy
of the Tibetan Qing Administration, written by Sungyun 184

Э. Пүрэвжав, М. Очирцэнд
Монгол Улс дахь нутгийн аялгуу судлалыг архивын баримтаас
тодруулах нь 197

Т. Сайнжаргал
Үндэсний Төв Архивын сан хөмрөг дэх Түшээт засаг
гүн Балдардоржийн захидлын мэдээг мөшгөх нь 213

М. В. Федорова
Вклад Я. П. Шишмарева в формирование монгольского собрания
Российского этнографического музея 221

Н. Хатанбаатар
"Богд Жибзундамбын анхан төрлийн нэр оршивой" хэмээх сурвалжийн тухай 235

Н. Хишигт
О. И. Макстенек: Монголын тухай илтгэл, мэдээллүүд (1920-1921 он) 241

С. Цолмон, Ц. Энхчимэг
Еще раз о Золотоордынских тамгах Крыма 250

Ц. Цэрэндорж
Солонгосын Чосөнъ улсын үед монгол хэлний сургалтад ашиглаж байсан ном, сурах бичгүүдийн нэрийг тодруулах нь 262

S. Chuluun, Agata Bareja-Starzyńska
On the documents of the first population and statistical census of Mongolia in the 20th century kept in the archive of prof. W.Kotwicz in Cracow, Poland 274

Ц. Энхжаргал
Таван жилийн төлөвлөгөөг сайжруулах асуудалд холбогдох баримтын тойм (Монгол Улсын Үндэсний Төв Архивын материалаар) 291

ИЛТГЭГЧДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ 310

DOI 10.48612/IVRRAN/vaz3-kmz1-dzpp *Г. Баярмаа (Монгол Улс)*

БЕРЛИНИЙ УЛСЫН НОМЫН САНД ХАДГАЛАГДАХ МОНГОЛЫН БУРХАНЫ ШАШИНД ХОЛБОГДОХ БАРИМТЫН ТУХАЙ

Товч агуулга: ХБНГУ-ын Берлин хот дахь Улсын номын санд Монголын түүх, шашин, эрх зүйн түүхэнд холбогдох олон гар бичмэл сурвалж, газрын зураг хадгалагдаж байдаг.

Цуглуулагчид, аялагчид монголчуудын бичиг үсгийн соёлд холбогдох монгол соёлын өвийг XVIII-XX зууны эхэн үед цуглуулж чадсан нь өдгөө Германы улсын номын сан, Угсаатны зүйн музей, Линден музей зэрэг 12 газар хадгалагдаж байна. Эдгээр цуглуулгыг түүх, шашин, хууль эрх зүй зэрэг олон ангилалд хуваан 1961 онд Вальтер Хайссиг, Клаус Загастер нар бүртгэн ном болгон хэвлэжээ.

Иймээс энэхүү илтгэлд дээрх цуглуулгаас Монголын бурханы шашинд холбогдох баримтуудыг тоймлон танилцуулахын сацуу Халхын шашны тэргүүн Богд Жибзундамба хутагтын түүхэнд холбогдох "*Богд Жибзундамба хутагт гэгээний зарлиг оршвой*" гэх тод үсгээр бичсэн хоёр гар бичмэлийг бусад монгол, төвөд хэлээр бичигдсэн зарлиг сургаалтай харьцуулан жишиж үзсэн тухайгаа өгүүлэх болно.

Түлхүүр үг: Лүндэн, зарлиг, сургаал, Бурханы шашин

Баярма Ганбат

О ДОКУМЕНТАХ И РУКОПИСЯХ ПО МОНГОЛЬСКОМУ БУДДИЗМУ, ХРАНЯЩИХСЯ В ГОСУДАРСТВЕННОЙ БИБЛИОТЕКЕ БЕРЛИНА

Аннотация: В Государственной библиотеке Берлина хранятся многочисленные рукописные источники и карты, относящиеся к Монгольской истории, религии и правовой истории.

В XVIII - начале XX вв. коллекционерам и путешественникам удалось собрать значительное количество предметов и рукописей по монгольской культуре и письменности, что ныне составляет большую коллекцию культурного наследия монголов, хранящегося в Германии, в 12 местах, в том числе в Государственной библиотеке, Этнографическом музее и Линден-музее и др.

В 1961 г. эти коллекции зарегистрированы немецкими учеными Вальтером Хейссигом и Клаусом Загастром и изданы в виде сборника документов с подробной тематической классификацией источников. Поэтому, в докладе, поставлена задача дать из этих коллекций лишь краткий обзор буддийских рукописей и провести сравнительный анализ 2 источников под названием “Указ светлейшего Богдо Джибзундамбы хутухты” на ясной письменности, посвященных главе буддийской религии Халхи — Богдо Джибзундамбе хутухте с другими указами и учениями, написанными на монгольском и тибетском языках.

Ключевые слова: наставления, указы, учения, буддийская религия

Бурханы шашинд холбогдох ном судруудаас танилцуулах нь ХБНГУ-ын Берлин хот дахь Улсын номын сангийн Дорно дахины гарын бичмэлийн Төв Азийн хэсэг дэх Монгол номын сан хөмрөгт халх, ойрад, халимаг, буриад бичиг номын арвин их өв хадгалагдаж байна. Эдгээр цуглуулгыг Вальтер Хайссиг, Клаус Загастер нар түүх, шашин, хууль эрхзүй зэрэг олон ангилалд хуваан “Mongolische handscriften blockdrucke landkarten” гэх бүртгэл номыг хэвлэн гаргажээ [Walther Heissig, Klaus Sagaster: 1961]. Уг ном 2 бүлэгтэй.

Нэгдүгээр бүлэгт: гар бичмэлүүдийг 22 төрөл зүйлд хуваан ангилж түүх судлал, намтар, Чингис хаан, яруу найраг туульс, ардын яруу найраг аман зохиол, ёс суртахуун, ёс заншил уламжлалт шашин, мэргэ зурхай, одон орон, Хятад зохиолын орчуулга, Энэтхэг, Төвөд гаралтай түүх, бурханы шашны судар, сургаал ба тайлбарууд, мөргөл залбирал, христийн шашин, боловсрол ба хэл, захиргаа, улс төр, хууль, анагаах зэрэг хэсгүүдэд бүлэглэн бүртгэжээ.

Хоёрдугаар бүлэгт: Халх, Өвөр Монголын хошуудын XX зууны эхэн үед зурагдсан181 хошуу нутгийн газрын зургийн бүртгэл байх аж.

Иймээс уг номын санд хадгалагдаж буй бурханы шашны судар ном, багш дээдсийн намтар, бурханы шашны уран зохиол, сургаал зэрэг олон төрөл зүйлийн монгол хэлээр монгол, тод бичгээр бичигдсэн бичгийн өвийг тоймлон танилцуулъя.

1 бүлгийн 13 хэсэгт (2,6,7,10,11,12,14,15,16,17,20,21,22) бурханы шашинтай холбоотой баримтууд хадгалагдаж байна. Жишээлбэл,

- Намтар зохиол 7 гар бичмэл — Атиша намтар 3 гар бичмэл, Нэйж тойны намтар, Галдан ширээт хутагтын намтар, VII Далай ламын намтар
- Бурханы шашны ёс суртахууны зохиол 8 гар бичмэл — Эрдэнийн

сан субашид 2 гар бичмэл, Мэргэн тэнэг шинжлэх төгс буян сайн номлол цагаан лянхуан баглаа, Өсөн дэлгэрэх хань номлосон шастир оршвой зэрэг

- Зан үйлийн 26 багц, дотроо олон судар хадгалагдана. Үүнд: Галын тахилга судар оршвой, Хутагт цагаан овооны судар оршвой, Газар усны чадагч нэрт судар, Цагаан овооны судар оршвой, Газар усны номхотгох дарлан чадагч нэрт судар оршвой, 13 Алтай, Гэсэрийн сан оршвой, Нууц номлосон судар, Сүлд тэнгэрийн сан оршвой гэх мэт
- Залбирал 89 гар бичмэл — Илт төгс нөгчсөн 35 сайбар одсон шүтэж унал наминчлал зан үйл бусдын тусын нарны гэрэл хэмээгдэх оршвой, Ариун өв сан нэр оршвой, Лама гүрү манзушир түүнчлэн ирсэн төгс ном мөн алдаршсан, Арван бурханы зарлиг оршвой гэх мэт
- Бурхан шүтээнтэй холбогдох 16 гар бичмэл — Сайн галавын 1000 бурханы нэр, Ялж төгс нөгчсөн бурхан багшийн гэгээний ариун намтар цадиг гайхамшигт зохиол эндүүрэл үгүй өгүүлсэн сайбар одсон дээд явдлын сан хэмээгдэх тэргүүн боть оршвой, Сургаалын орны зохиолын өгүүлсэн үг ариун орны эрдмийн тодорхой үзүүлэх билгийн толь хэмээгдэх оршвой, Гандан зуу дотор эрх үгүй хэмжээ ач тусалъя хамт товчлон хураасан эрдэнийн эрх нэрт оршвой гэх мэт
- Бурханы шашны сургалт ба тайлбар — Их бодь мөрийн зэрэг оршвой, Гурван төрөлхтний анхааран авахын бодь мөрийн зэрэг оршвой мөрийн зэргийн хөтөлбөр тогтоосны бичиг оршвой, Бодь мөрийн зэргийн авах анхаарахын ялгал дээж бичиг толь хэмээгдэх оршвой, Албан найман хэрэгт хэмээх сургаал оршвой гэх мэт
- Бурханы шашны судар ном 122 — Билиг барамид нэрт судар оршвой, Хутагт дээдийн алтан гэрэл эрхт судар хаган нэрт их хөлгөн судар оршвой, Хутаг дээд Алтан гэрлийн эрхт судар, Элбэг билэг барамид, Хутагт 8000-т нэрт их хөлгөн судар оршвой гэх мэт
- Удирдлага, эрх зүйн 92 гар бичмэл буйн дотор Жибзундамба хутагт болон сүм хийдийн нэрсийн жагсаалт зэрэг иргэний шинжтэй баримтууд байдаг. Жишээлбэл, Даштойсомлин аймгийн мэдээч нар дээдсийн тушаалтныг дагаж аймгийн арван хаалга бүрд нэгэн дарга тавьж захирсан данс, Хамба номун хан

тамгыг хамаарсан дэд хамба, Шанзудба, Да лам нарын бичиг, Буддын шашинтан буриад монголчуудын Ацгатын хийдэд 1922 оны октябрийн 19-29 өдрүүдэд тогтоосон чухлаар байгуулсан тогтоомж зарчмууд оршвой, Манж, Монгол, Хятад, Төвөдөөр бичигдсэн сүм хийдийн нэрс, Бэйсийн зэрэг засаг Жибзундамба хутагтын VIII дүрийг ширээнээ залах Бат-Оршил өргөх наадам үйлдэхэд амбастанд гүн Насан-Очирыг мордуулах ба даншүгийн эл хэрэглэлийг гаргаж бэлтгүүлэн гүн Насан-Очирт илгээх эх зэрэг судар ном, нугалбар бичиг, сурах бичиг зэрэг олон төрөл зүйлийн бичгийн дурсгалууд болно.

Герман улсад хадгалагдах гар бичмэлүүдийн дийлэнх хувийг бурханы шашны түүхэнд холбогдох эх сурвалж, гар бичмэлүүд эзлэх бөгөөд, тэдгээрийн дотроос Халхын шашны тэргүүн Жибзундамба хутагтын тод бичгээр бичигдсэн нэгэн зарлиг сургаалыг судлагдахуун болгож, бусад ижил төстэй зарлиг сургаал лүндэнтэй харьцуулан үзэхийг оролдлоо.

“Богд Жибзундамба хутагт гэгээний зарлиг бичиг оршвой” гэх нэгэн сургаалын тухайд

Халхын шашны тэргүүн V, VII, VIII Жибзундамба хутагтуудын зарлиг сургаал, лүндэнгүүд бидний үед хадгалагдан ирсэн билээ. Зарлиг сургаалын хоёр хувилбар Герман улсын номын санд тод болон монгол бичгээр хадгалагдаж байгаа нь

“Богд Жибзундамба хутагт гэгээний зарлиг бичиг оршвой” [Ms. or. oct 412]

“Богд Жибзундамба хутагт гэгээний зарлиг бичиг оршвой” [Ms. Or. Fol 1374]

“Жибзундамба хутагтын буяны сургаал хэмээх шүлэг оршвой” [Libr. Mong 127] гэх гурван гар бичмэл болно. Эдгээр 3 сургаал, зарлигийн хоёр нь нэгэн цаг үед тод үсгээр бичигдэж тараагдсан зарлиг бол, нөгөө нь монгол бичгээр бичигджээ.

Энд тод бичгээр буй ижил агуулгатай хоёр гар бичмэлийг авч үзлээ. Гар бичмэлүүд 1887 он гэсэн бүртгэлтэй.



Зураг 1. “Богд Жибзундамба хутагт гэгээний зарлиг бичиг оршвой”
[Ms. Or. Fol1374]
13 хуудас 24, 26 мөр гар бичмэл, хатуу цаасан дээр бичигдсэн байна.



Зураг 2. “Богд Жибзундамба хутагт гэгээний зарлиг бичиг оршвой”
[Ms. or. oct 412]
15 хуудастай, нэг нүүрт 23-24 мөр бичээстэй, хатуу цаас дээр бичигдсэн.
Нүүр, ар хавтастай.

Герман улсад буй халимаг, ойрад гар бичмэлүүд Бернхард Юүлгийн (1825-1886) цуглуулга болохыг Вальтер Хайссиг “...гар бичмэлүүдийн нэлээд нь халимаг, монгол ном судрын тасархай хуудаснууд, зарим нь XVII зууны үеийн ихэд бохирдож, зарим хэсэг нь шатсан, шавар шорооны ул мөр үлдсэн хуучин бичвэрүүдийн үлдэгдэл байна. Бернхард Юүлг тэр олон тасархай хэсгийг хэнээс авснаа хэлээгүй аж. Монгол, халимаг хэл дээрх ном судруудыг бичсэн хэлний шинж, тэдгээрийн насжилтаас харахад Умард Монгол-Ойрадын хил хязгаар нутгаар аялж явсан жуулчин хүн л тэндээс тэдгээрийг олж авсан байх магадлалтай” [Урангуа 2018: 141] хэмээсэн байдаг. Үүнээс үзвэл, зарлиг бичгүүд

Бернхард Юүлгийн цуглуулгын Монгол-Ойрадын нутгаас авчирсан судар номын дунд ирсэн байх боломжтой. Хоёр гар бичмэл ижилхэн нэг бичвэртэй байгаа нь тухай бүс нутгийн айл бүрд тараагдан шүтэгдэж байсныг илтгэнэ. /"Богд Жибзундамба хутагт гэгээний зарлиг бичиг оршвой" сургаалыг Хавсралтад бүрэн эхээр нь оруулав/.

Энэхүү сургаалтай ижил төстэй тод үсгээр бичигдсэн Жибзундамба хутагтын сургаал зарлигууд өдгөө ч Ойрад монголчуудын дунд хадгалагдсаар байдаг. Тухайлбал, Ховд Их сургуульд тод үсгээр ойрад аялгуугаар бичигдсэн "*Богд Жибзундамбын лүндэн оршив"*, "*Богдын зарлиг оршив"* гэх хоёр гар бичмэл хадгалагдаж байна.

"*Богдын зарлиг оршив*"

Судрын эхлэл:

Ом сайн амгалан ариун биеийн чанар олсон. Арван орны ялгуусан Богд Жавзандамба хэмээн миний зарлигийг та мину сонсогтун. Би дөчин есөн төрөл болсон билээ. Над мөргөсний мөргөх үгүй хүмүүн амьтан олон тулд бичиж ирэв би. Мөргөх үгүй амьтан над мөргөтүгэй. Та миний Бодала уулын орой дээр ч нар ч харах нь альхан толуни дотор биш та минь хүрэхүй бармас энэ чөлөөт сайн оронд төрөөд ном буян эс үйлдэв ээ та минь

Судрын төгсгөл:

Богд Жибзундамба гэгээн мину зарлиг дамжиг үгүй биширвээс хол ойр гэж үгүй сахих нь магад биз ээ. Энэ зарлиг бичиж хүн бүгдэд өлзийтэй болмуй. Ум сайн амгалан болтугай. Сэтгэшгүй энэрэхүйн их санд нүдээр үзэж хир үгүй мэдэхүйн эрхт Манзушир Цастын мэргэдийн оройн чимэг Зонхова алдаршсан сайн оюутын өлмийд залбирмуй. Ум ма ни бад мэ хум [Ховд Их сургуульд 2022: 33-34] гэх бичвэртэй 6 хуудас зарлиг болно.

"Богд Жибзундамбын лүндэн оршив"

Судрын эхлэл:

Сухавадийн орон буй ч ирсэн ариун чанарт олон төрөл авсан Богд Жибзундамбын зарлиг хөндөж сонсогтун.

Урьд төрөл авсны инагшид дөчин есөн төрөл үзүүлэн буй. Буянтны эс мөхсөний тул эргэж энд ирэв.

Мөргөе хэмээхүй их бага амьтан сонсогтун. Энд ч нирваанд одсон хойно эргэл үгүй огторгуйн алтан дусал нэрт бурхан болж төрсөн хойно үхэхийн үнэн хураасан хойно барагдахуйяа үнэн хураасан хойно тархины үнэн хадам ихэдсэн

Судрын төгсгөл:

Сонсвоос зулын гэрэлд адил
Мунхаг хүн сонсвоос харанхуй шөнө адил
Муу санаат хүмүүн сонсвоос адгуус мал адил
Дэмий хүмүүн сонсвоос тань сажин сахиусны мэдтүгэй
Түгэн илгээснээр гурван эрдэнэ аврах болтугай
Тэмдэг бичиг тараая
Зургаан зүйл хамаг амьтан дэлгэрэх болтугай
Хамаг амьтан жаргах болтугай
Сарва мангалам [Ховд Их сургуульд 2022: 33-34] гэсэн зарлиг болно. Харамсалтай нь бүтэн эхээр нь олж үзэж чадсангүй. Тус хоёр зарлиг лүндэнгийн эхлэл хэсгүүд Герман улсад хадгалагдах тод зарлиг бичигтэй ижил утгатай аж. Иймээс "*Богд Жибзундамба хутагт гэгээний зарлиг бичиг оршвой*" гэх гар бичмэл Халх болон бусад монголчуудын дунд тараагдан шүтэгдэж байсан эсэхийг тодруулан үзэхэд, агуулгын хувьд *"Бүрхэг өдрийг гийгүүлэгч зул*" [Богдын лүндэн: 2010] хэмээх сургаалтай ихэнх хэсэг нь ижилхэн болохыг олж мэдлээ.

"Жибзундамба хутагтын зарлиг бичиг оршвой"

Судрын эхлэл:

Өлзийхутаг орших. Ум сайн амгалан болтугай
Сухабадын орноос бууж ирсэн. Ариун бие олсон, олон төрөл үзүүлсэн
Арван орны Богд Жибзундамба лам гэгээний зарлиг бичиг сонсогтун
Инагш дөчин есөн төрөл үзүүлэв. Иш уулзаж мөргөсөн амьтан олон тул эргэж ирэв

Судрын дунд хэсгээс:

Арван орны Богд Жибзундамба лам гэгээний алтан бичиг хүлцэж сонс
Хэн бичиж байваас сайн буй. Хан харц их бага амьтан
Богд Жибзундамба гэгээний зарлиг. Цаг цөв болсны тул хамаг амьтанд тараав
Үүнийг тэр миний шавь нар бүгдээр. Харанхуйг гийгүүлж гэгээн зул
Хамаг амьтан хагацал үгүй сууваас сайн

Судрын төгсгөл:

Муу ёр осолдох болтугай. Өлзий хутгийн цог бадран
Замбуу тив ертөнцөд. Насан хутаг тогтох болтугай. [Ms. Or. Fol 1374]

“Бүрхэг өдрийг гийгүүлэгч зул”

Судрын эхлэл:

Лам гурван эрдэнэд мөргөн итгэн өчмүй. Нигүүлсэхүйн гохоор татан соёрх. Сухабадын орноос бууж ирсэн. Ариун биеийн чанарт Жавзандамбын зарлигийг хүлээж сонсохтун. Эртний төрлөөс нааш дөчин есөн төрлийг өнгөрүүлэв. Эс уулзаж мөргөсөн амьтан олон тул эргэж ирэв би

Судрын дунд хэсгээс:

Их бага амьтан Богд гэгээний зарлигийг сонсож. Бишрэн бичиж тахивал сайн бөлгөө

Богд Жавзандамба гэгээний зарлигийг. Цаг цөвүүн болсон энэ үед тараанам буюу

Миний энэ зарлигийг шавь нар бүгдээр тараацгаа. Бүрхэг өдрийг гийгүүлэгч гэгээн зул

Хамаг амьтан хагацалгүй суувал сайн санж

Судрын төгсгөл:

Гурван эрдэнийн аврал болтугай. Бурханы шашин дэлгэрэх болтугай

Сайн буян арвидах болтугай. Өлзий хутаг орших болтугай [Богдын лүндэн 2010: 53] хэмээжээ.

Зарлиг сургаалын эхэн, дунд, төгсгөл хэсгээс авсан дээрх мөртүүд үг үсэггүй ижилхэн биш боловч агуулгын хувь тохирч буйг харж болно. Мөн ижил утгатай хоёр зарлигт ялгаатай зүйл ч багагүй байна. Ойрадуудын дунд тараагдсан эхэд ороогүй агуулга Халхчуудын дунд дэлгэрсэн эхэд оржээ. Тухайлбал, халхчуудад хандаж

Халхын орны өглөгийн эзэд

Намайг гэж санавал

Энэ зарлигийг минь хичээхтүн

Архи тамхи үл хэрэглэх тухай

Архи тамхи бүү уу

Харанхуй шөнө бүү яв

Хэрүүл шуугиан бүү гарга

Бурханы номд шамдах тухайд

Дээд буянтан гурван зүйл юм унш

Дунд буянтан Жадамба, Алтангэрэл унш

Адаг буянтан маань мэгзэм түг түм унш [Богдын лүндэн 2010: 53] гэх хэсгүүдийг нэмэн зарлиглажээ. Үүнээс үзвэл энэ зарлиг монголчуудын дунд өргөн тархсан сургаал болох нь илэрхий аж.

/Хавсралтад бүрэн эхээр оруулав/

Дээрх лүндэн зарлигуудыг хэддүгээр Жибзундамба хутагт айлдсан болохыг тодруулбал: Монголын Үндэсний Номын сангийн Монгол судлал, гар бичмэлийн сан хөмрөгт Монголын Богдуудын зарлиг лүндэнгүүд төвөд болон монгол бичгээр 30 гаруй хадгалагдахын сацуу ОХУ-ын Санкт-Петербург, Шведийн Стокгольм, Данийн Копенгаген, Германы Бонн, Унгарын Будапешт [Богдын лүндэн: 2002] Германы Берлин зэрэг хотын номын сангуудад хадгалагдаж байна.

Монголчуудын дунд хамгийн их зарлиг лүндэн талбисан хутагт бол VIII Богд Жибзундамба хутагт юм. Тухайлбал, *Наймдугаар Богд гэгээний лүндэн сургаал болой, Наймдугаар Богд Дарнат Жибзундамбын гэгээний гэгээний лүндэн оршвой, Богдын лүндэн наймдугаар Богдын айлдсан сургаал буй, Богд Жибзундамба хутагтын наймдугаар дүрийн лүндэн, Богдын лүндэн* [Монгол Улсын 2020: 153-158] *Богд Жавзандамба гэгээний аяа гайхамшигт лүндэн оршивой* [Богдын лүндэн 2002: 9] зэрэг олон лүндэн зарлиг бий. Эдгээр зарлигуудын бичвэрийн төрөл ижил мэт. Жишээлбэл, МҮНС дахь “Богд Жибзундамба зарлиг лүндэн”-д

“*...Ум сайн амгалан болтугай. Сухабадын орноос бууж ирсэн. Номын биеийн чанар илэрсэн. Олон төрөл хувилсан Богд Жибзундамбын зарлиг. Одоо их, бага амьтан сонсогтун. Төрсний эцэс үхэх үнэн. Хураасны хойно барагдах нь үнэн. Харам хөрөнгө багадсаар буяны хөрөнгө барагдах болно. ханилан жаргаж суусаар буянаа алдах болно. Буянаа алдсанаар ханилагч хүнээ үл харна та. Хүсэл шунал ихэдсээр шагшаабадад их эвдрэл болно. Сайн хүсэлт хуврагт эс мөргөснөөр тамд унах болно. ...Ариун орныхоо богд Жибзундамбынхаа зарлигийг сонсогтун. Бичиж аваад гэртээ шүтэж тахь. Хаан харцсын орон ба хамаг амьтан цөм энэ зарлигийг тараахтун....Миний шавь нар хамаг амьтан хагацалгүй шүтвэл. Харанхуй шөнийг гийгүүлэгч зул мэт”* [Богд Жибзундамба: 4656/96] зэргээр ижил утга агуулгатай зарлиг байгаа нь VIII Богд Жибзундамба хутагтынх байх боломжтой байна. Магадгүй нэг лүндэн зарлиг олон нэрээр хадгалагдсан байхыг үгүйсгэхгүй.

VIII Богд Жибзундамбын лүндэнд Халх, Өвөр монголчуудад шүтэгдэж байсныг “Богд Жэвзүндамба гэгээний Аяа гайхамшигт бошго оршвой”-д “*...Ар Халх дөрвөн аймаг, шавь долоон хошуу. Өвөр дөчин есөн хошуунд залагдаж ирсэн билээ би”* [Пүрэвбат 2018: 147] гэснээс харж болох ба Буриадуудын дунд хадгалагддаг “*Туяат лүндэн*”, “*Туяаны лүндэн оршвой*” гэх зарлигууд, Ойрад, Халимагуудын дунд тараагдсан *“Жибзундамба хутагтын зарлиг бичиг оршвой”, “Богдын*

зарлиг оршив” гэх лүндэнгүүд нь Жибзундамба хутагтууд бүх монгол угсаатнуудад хүндлэгдэн шүтэгдсэн блам байсныг гэрчилж байна.

ДҮГНЭЛТ

ХБНГУ-д Монголын гэх тодотголтой олон бичгийн сурвалж, эд өлгийн зүйл хадгалагдаж байгаагаас ихэнх нь Берлиний Улсын номын санд байдаг аж. Сурвалж бичгүүдийн олонх нь Монголын бурханы шашны зан үйл, түүхэнд холбогдох ном судар, эх сурвалжууд болно.

Халхын шашны тэргүүн Богд Жибзундамба хутагтуудын олон сургаал зарлиг бидний үед хадгалагдан ирсний нэг нь тод үсгээр ойрад аялгуугаар бичигдсэн “Жибзундамба хутагтын зарлиг бичиг оршвой” сурвалж юм. Хутагт монгол овогтнуудад зориулан өөрийн сургаал лүндэнг талбидаг байсны томоохон жишээ энэ зарлиг билээ. Монголчууд Богд Жибзундамба хутагтын лүндэн зарлигийг гараас гар дамжуулан уншиж, хуулбарлан сүсэглэн залбирч, мөрдөн дагаж шүтэж биширч иржээ. Жибзундамба хутагтууд бол зөвхөн Халх 4 аймагт залагдсан ихээхэн блам байсангүй, нийт монгол угсаатнуудад шүтэгдсэн хамгийн нөлөө бүхий хутагт байсныг түүний лүндэн зарлигуудаас харж болохоор байна.

НОМ ЗҮЙ

Ms. Or. Fol 1374: Staatsbibliotik zu Berlin, Ms. Or. Fol 1374

Ms. or. oct 412: Staatsbibliotik zu Berlin, Ms. Or. oct 412

Богд Жибзундамба 4656/96: *Богд Жибзундамба* зарлиг лүндэн 4656/96. МҮНС, Монгол судлал, гар бичмэлийн сан хөмрөг.

Богдын лүндэн 2002: *Богдын лүндэн.* Хаадын сан . УБ.,2002.

Богдын лүндэн 2010: *Богдын лүндэн.* Хаадын сан УБ.,2010.

Монгол Улсын 2020: Монгол Улсын Үндэсний номын сан дахь Монгол бичгээрх сурвалж бичиг. Бүртгэл мэдээлэх ном зүй I. УБ., 2020.

Пүрэвбат 2018: *Пүрэвбат Г.* Их Монгол оронд уламжлагдсан Ирээдүйг эш үзүүлсэн бошгууд. УБ., 2018.

Урангуа 2018: *Урангуа Ж.* Герман дахь монголын бичиг соёлын өв // Historia Mongolarum, Tom 17. Fasc 8, УБ., 2018.т. 141

Ховд Их сургуульд 2022: *Ховд Их сургуульд хадгалагдаж буй тод үсгийн судруд*// Studia regionalia occidentalis Mongoliae II, УБ., 2022

Walther Heissig, Klaus Sagaster 1961: *Walther Heissig, Klaus Sagaster,* Mongolische handscriften blockdrucke landkarten, Franz Steiner verlag GMBN Wiesbaden 1961.

Хавсралт

ЖИБЗУНДАМБА ХУТАГТЫН ЗАРЛИГ БИЧИГ ОРШВОЙ

Өлзийхутаг орших Ум сайн амгалан болтугай
Сухабадын орноос бууж ирсэн. Ариун бие олсон, олон төрөл үзүүлсэн
Арван орны Богд Жибзундамба лам гэгээний зарлиг бичиг сонсогтун
Инагш дөчин есөн төрөл үзүүлэв. Иш уулзаж мөргөсөн амьтан олон тул эргэж ирэв
Тиймийн тул тэнд мөргөмүй хэмээн. Үүний тул их бага амьтан сонсогтун
Та хойно нирваан үзүүлбээс. Эргэл үгүй огторгуйн алтан дусал нэрт бурхан болох болмуй
Төрсний хойно үхэх нь үнэн. Хурсны хойно тарах нь үнэн
Хураасны хойно барагдах нь үнэн. Хармын хүрэх ихэд юу
Буян хөрөнгө хатуу үнэн болмуй. Ханилан жаргаж суух буянаа алдах үнэн болмуй юун
Буянаа алдсаныг болох эс үзмүй. Хүсэлт ихэдсээр шагшаабадын завсар мэт эвдрэх болмуй.
Хүслэнт хувраг уг эс учирсан юу. Элдэв зүйлийн тамд унах болмуй
Эрүүт там эс сонсов та. Үл мэдэхийн эрхээр явбаас билгийн илдээ мохооном та
Олом үгүй далайд унасны хойно гомдох юун тус болмуй
Арван орны Богд Жибзундамба лам гэгээний алтан бичиг хүлцэж сонс
Хэн бичиж байваас сайн буй. Хан харц их бага амьтан
Богд Жибзундамба гэгээний зарлиг цаг цөв болсны тул хамаг амьтанд тараав
Үүнийг тэр миний шавь нар бүгдээр
Харанхуйг гийгүүлж гэгээн зул. Хамаг амьтан хагацал үгүй сууваас сайн
Сайхан жаргалд уусаж. Хамаг амьтан гэнэт үгүй болон
Хагацаж альхан бэ барьж одохуйд юутай муухай билээ. Өндөр уулнаас унаваас босохуйд бэрх. Оломгүй далайд унасны хойно гомдож юун тус гарах нь бэрх
Халуун тогоонд хуурсан хойно арвай мэт. Ямарчлан халуун ширүүн ахуй тухайд хүрч
Сайхан жаргал хамаг үзмүй. Насны хэмжээ ирэхийн урьд
Хамаг амьтан гэнэт үхэх юутай муухай билээ. Хайрлан жаргаж суухуйд өвдвөөс
Лам гурван эрдэнийн ачаар хэмээн итгээд. Харин хойно мартаж орхиод
Ховнин шивнэн хэлэлцэж с явах бармас та минь. Энэлгэн явж эрлэгт юу хэлнэм та минь

Хармагц үл ханах шийтгэлтэн сонсож үл ханах. Шунаг санаатан амьтан эд таваар ер
Шунахайран далдад. Үхэх биеэ үл санаж
Арван найман тамд унах биеэ үл мэдэж. Хорхой мэт хүрэхүй бармас та минь
Номыг сонсвоос чих тань дүлий. Элдэв юу хэмээж үл мэдэх санаа тань бүтээе
Онож одох биеэ мэдэж жаргах хүн хэмээмүй та минь. Урьд авч одох эрлэг юу хэлнэм та минь
Эрдэнэт хүний биеийг оловч түргэн хагацан одох юутай муухай билээ.
Хамаг амьтны тусын тулд. Бодала уулын үзүүрт гарч. Зургаан зүйл амьтан цөв өнгө үзвэй
Цагаан сарын шинийн 7-нд солонго татаж. Мянган нүдэт Хоншим бодисадва энэ ертөнцийн зовлонг үзэв
Тиймийн тул бие батлан өгье гэж ам бүү алд
Үгүй гэж бүү гомд. Баян гэж бүү омгорх. Тэнгэрийн хур үгүй гэж бүү хараа
Дэлхий өвс үгүй гэж бүү хар. Сажныхувраг ам бүү
Хариу үгүй эм бүү зал хор болмуй.
Ертөнцийн дөрвөн далайд баригдсан хайрын бие тань
Бурханы зарлиг эс сонсвоос. Та лам багш таныг эс сонсвоос. Гурван эрдэнийн зарлигийг эс сонсвоос
Эрлэгийн элч ирсэн хойно юу хэмээнэм та минь. Хэт авч одоод асуубаас юу хэмнэм та минь
Маргааш нөгөөдөр хэмээсээр ном буян үл үйлднэм та минь. Хүчит эрлэгийн элч ирсэн хойно юу хэлэх билээ та. Сажны хувраг тойн болбоос
Хотол маймаанд орхимжоо дотуур чангахан боогоод
Хотлын хурим хэмээвээс гүйн явах бол. Ном сажин үл санаж. Бурхны ном үл сонсож.
Сажин юугаа гутаанам та минь. Гурван эрдэнийн зарлиг сонсож
Бүгд бурханы ном мэдэх. Бүгд харин хар хүний явдлаар яваад
Сажин ном хэмээвээс ажиг сэжиг үгүй явах тань юун билээ та минь

БҮРХЭГ ӨДРИЙГ ГИЙГҮҮЛЭГЧ ЗУЛ

Лам гурван эрдэнэд мөргөн итгэн өчмүй. Нигүүлсэхүйн гохоор татан соёрх!
Сухабадын орноос бууж ирсэн. Ариун биеийн чанарт Жибзундамбын зарлигийг хүлээж сонсогтун!
Эртний төрлөөс нааш дөчин есөн төрлийг өнгөрүүлэв би
Эс уулзаж мөргөсөн амьтан олсон тул эргэж ирэв би. Тиймийн тул та мөргө. Үүний тул сонс та минь! Эхнээс хойш нирваанд одсоны дараа
Эгээрэлгүй огторгуйн Алтан дусал нэрт бурхан болно би
Төрсний хойно үхэх үнэн. Хураасны хойно барагдах үнэн. Хурсны хойно тарах үнэн. Хуримын хөрөнгө ихэдсээр буяны хөрөнгө хатуу болно. Ханилан жаргаж суусаар буянаа алдах болно.
Хүсэл ихэдсээр шагшаабадын шат үе эвдрэх болно
Хүслэнт хувраг лугаа эс уулзсанаар тамд унах болно
Эрүүт тамыг эс сонсов та. Үл мэдэхийн эрхээр явсаар билгийн илдээ бүү мохоогтун!
Оломгүй далайд унавал гарахад бэрх. Их бага амьтан богд гэгээний зарлигийг сонсож
Бишрэн бичиж тахивал сайн бөлгөө. Богд Жибзундамба гэгээний зарлигийг
Цаг цөвүүн болсон энэ үед тараанам буюу
Миний энэ зарлигийг шавь нар бүгдээр тараацгаа!
Бүрхэг өдрийг гийгүүлэгч гэгээн зул. Хамаг амьтан хагацалгүй суувал сайн санж
Үхээд одоход юутай муухай билээ. Өндөр уулын оргилоос унавал босоход бэрх
Оломгүй далайд унавал гарахад бэрх. Үлгэрлэвэл халуун тогоонд хуурсан арвай мэт
Халуун бүлээн нуурт орвол сайхнаар жаргах мэт. Ханилан суугаад харшлах өвчинд нэрвэгдэхийн цагт. Гурван эрдэнийн ачаар эдгээд боссон хойно. Ховлон шивнэн хэлэлцэж явагч тэнэгүүд
Зовоогч эрлэгүүдэд юугаа хэлнэ та. Ертөнцийн жаргалд юунд ташуурнам
Сургавал үл сонсогч чих тань дүлий. Элдэвчлэн хэлэвч санаа тань битүү
Нүдээ аньж унтахын жаргал хийвэл муухай. Гэтэж ирээд зовоогч эрлэгүүдэд юугаа хэлнэм та
Харамлаж үл дуусах хомхой сэтгэл. Шунаж үл дуусах мунхаг санаа
Аа идээний амтанд шунахайран. Арван найман тамд унахаа үл санагч бармас хөөрхийс

Будалан уулын оргилд гарч. Зургаан зүйл хамаг амьтны зовлонг үзүүлбэл
Цагаан сарын шинийн долооны өдөр солонго татаад. Мянган нүдэт Хоншим бодисад энэ амьтныг ам алд. Үгүйтэй гэж бүү гомд. Баян гэж бүү омгорх. Тэнгэрийг хур үгүй гэж бүү хараа.
Шашны хуврагт ам бүү алд. Өглөг үгүй эм бүү уу. Уувал хор болно
Ертөнцийн дөрвөн далайд баригдсан хайран бие тань. Гурван эрдэнийн алтан зарлигийг эс сонсов уу. Багш лам тань эс сургав уу. Маргааш нөгөөдөр хийе гэсээр. Насаа юунд номгүй нөгчөөнө вэ.
Орхимжоо дундуураа шавхийтэл бүслээд. Гүйн харайн явагч, худалдаа хуримд шунахайран
Шашин номд үл шамдагч хуврагууд минь. Шашныг минь юунд гутаанам бэ.
Та минь бурхны зарлигийг сонсож. Номын утгыг мэддэг атал
Хар хүний ёсоор сэжиггүй явдаг тань юу вэ. Хоёр ташаандаа алт мөнгө зүүж
Хоёр хацраа улайтал ширдэж. Хоолой хүзүүнд шүр сувд чимэгч хатад
Эхнэр хүүхэд хорт тачаангуйг бүтээхээс өөр юун. Эрлэгийн элч ирсэн хойно юун тус болох
Хавар ургасан навч цэцэг хэдийгээр найгалзавч. Намрын нэгэн шөнийн хяруунд хоосон болох
Эцэг эх ах дүү нар хэчнээн хүрээлэвч. Үхэхийн цагт юун тус болох. Харин учирсан нэгэн хувраг тус болно. Түүнийг мэдсээр байж шашны хувраг ирэхлээр. Угтаж үл гарах, босож үл өгөх
Жийсэн хөлөө үл татах. Тогоонд чанасан идээгээ харамлан буруу харах
Үрээ зодох, айлын хүнд ховлон шивнэн хэлэх. Элэглэн инээлдэж үүдэндээ суулгах
Харин хар хятадыг орой дээрээ. Үхэхийг үл санагч хайран амь нас
Та минь хөөрхий барамс. Лам мэргэдийн бичгийг түргэн тараа
Гэртээ бичиж тахь. Нэгэн гэрт хонин жилт хүн үзэгдвэл
Тэр л даран чадах бөлгөө. Гөрөөс, нохой шувуунд тараа
Халхын орны өглөгийн эзэд. Намайг гэж санавал
Энэ зарлигийг минь хичээгтүн! Намрын дунд сарын арван зургаанаас нааш
Таних танихгүй өвчин хийгээд. Хоолой хавдах, гэдэс хөөх, гар хөл хавдах хийгээд
Малд үхэл олон болох. Тиймийн тул эв эе. Тангараг санваар бүү эвд.
Архи тамхи бүү уу. Харанхуй шөнө бүү яв. Хэрүүл шуугиан бүү гарга. Шалтгаан нь юу ч байж магадгүй.

Дээд буянтан гурван зүйл юм унш. Дунд буянтан Жадамба Алтангэрэл унш. Адаг буянтан маани мэгзэм түг түм унш. Даллага ав. Сан бүү тасал
Олон хувраг үдэш бүр Билиг барамид унш. Намайг гэж санавал маань мэгзэм барь
Дөрвөн зүгт хийморь хийсгэ. Шашны хүн сонсвол сарны гэрэл адил
Ухаантай хүн сонсвол бурхны бие адил. Номч хүн сонсвол зулын гэрэл адил
Муу санаат хүн сонсвол адгуус адил. Мунхаг хүн сонсвол харанхуй шөнө адил
Мунхаг хүн харанхуй шөнө адил. Тийм хүнийг шашны сахиус мэдтүгэй хэмээн танд тараан илгээмүй.
Гурван эрдэнийн аврал болтугай. Бурхны шашин дэлгэрэх болтугай. Сайн буян арвидах болтугай. Өлзий хутаг орших болтугай. Ум ма ни бад мэ хум
Сайн буяны хүчээр. Сайтар олсон энэ биеийг санаандгүй суусаар сарнин тарж магадгүй
Дээдсийн номыг сайтар шамдан шүтвэл сайн бөлгөө
Сайн буян арвидах болтугай
Ум сайн амгалан болтугай